



Самдангийн Дашдаваа  
(1937-2005)

Монгол улсын тэргүүний геологич, доктор, профессор Самдангийн Дашдаваа 1937 онд Завхан аймгийн Цагаанхайрхан сумын нутагт төрсөн. 1948–1958 онд бага дунд сургууль, 1958–1963 онд Монгол Улсын Их Сургуулийн геологийн салбарыг дүүргэсэн анхны арван гурван геологич инженерийн нэг төдийгүй анхны таван багшийн нэг, анхны тэнхимийн эрхлэгчийн нэг, анхны есөн деканы нэг, анхны геологич арван эрдэмтэний нэг, анхны арван профессоровын нэг байлаа.

Тэрээр 1977 онд Украин улсын ШУА-ийн Геохими эрдсийн физикийн хүрээлэнд “ Их хайрханы гянт болдын ордын геологи ба гарал үүслийн онцлог ” сэдвээр геологи - минералогийн ухааны докторын зэрэг хамгаалсан ба 1984 онд дэд профессор, 1993 онд профессор, ШУТИС–ийн хүндэт профессор цол тус тус хүртжээ.

С. Дашдаваа нь 1963–1967 онд МУИС–ийн геслогийн салбарт багш, 1967–1971 декан, 1972–1982 онд Политехникийн Дээд Сургуулийн хичээл ангийн эрхлэгч, 1982–1992 онд Техникийн Их Сургуулийн (ШУТИС) сургалт, хүмүүжил эрхэлсэн дэд захирал, 1992–2002 онд МУИС–ийн Геологи–Минералогийн тэнхимийн эрхлэгч, 2002 оноос тэргүүлэх профессороор үр бүтээлтэй ажиллаж байлаа.

Тэрээр бүхий л авъяас чадвар, эрдэм мэдлэг, ухамсарт амьдралаа Монголын геологийн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэж, сурган хүмүүжүүлэхэд зориулсан нэрт эрдэмтэн, геологич, сурган хүмүүжүүлэгч байв. Нэг сэдэвт зохиол, их дээд сургуулийн оюутанд зориулсан минералогийн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл туурвиж, мэргэжлийн чиглэлээр 80 гаруй төгсөгчийн бакалавр, магистр, докторуудын ажлыг удирдан хамгаалуулжээ.

С.Дашдаваа Геологи–Минералогийн ухаанаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн орлогч дарга, Шинжлэх Ухааны Академийн Бага чуулганы гишүүн, Монгол Улсын Боловсролын Академийн гишүүн, Хүдрийн ордын гарал үүслийн олон улсын нийгэмлэгийн гишүүн, Герман улсын Фрайбергийн Уул Уурхайн академийн гишүүн, МУИС-ийн Эрдмийн Зөвлөлийн гишүүний сонгуульт ажлыг нэр төртэй гүйцэтгэж байв. Түүний хөдөлмөр бүтээлийг төр засгаас өндрөөр үнэлж Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Алтангадас одон, Хөдөлмөрийн хүндэт медаль, боловсрол, шинжлэх ухааны болон бусад салбарын тэргүүний ажилтан цол тэмдэгүүдээр шагнагдаж байжээ.

Хүндэт профессор С.Дашдаваа багш таны ажил хэрэгч, төлөв даруу, нөхөрсөг, хүнлэг зан чанар, гэгээн дүр тань бид бүхний зүрх сэтгэлд үүрд мөнхрөн үлдэх болно.

МУИС–ийн Газарзүй–Геологийн факультет,  
ШУТИС–ийн Геологийн сургууль,  
ГЕОЛОГИЙН АСУУДЛУУД сэтгүүлийн эрхлэх зөвлөл.